

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨА-2021/112-18-ШТА-ГА

Зуунмод 2021 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Майцэцэг
Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn
Ахлах аудитор Ц.Саранчимэг
Утас: 70273204 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn
Аудитор Ж.Бямбацогт, Д.Бямбасүрэн, Г.Баянжаргал,
Т.Хүрэлбаатар
Утас: 70272287, 70273204, 70272248

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.	4
БҮЛЭГ А. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалт нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.	6
1.1 Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудад холбогдох хууль, эрх зүйн орчин бүрдэж, орон нутагт үр дүнтэй хэрэгжиж байна.	6
1.2 Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагууд зорилго, зорилтдоо нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	7
1.3 2017-2020 оны нийт төгсөгчдийн 54,4 хувь нь ажлын байраар хангагдсан байна.	8
1.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын материаллаг орчин бүрдэж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр харилцан адилгүй хангагдсан байна.	10
БҮЛЭГ Б. Хөрөнгийн тооллого, тооцоо бодолт хангалтгүй, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.	13
2.1 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төсвийн төсөлд өгсөн саналыг өөрчлөн баталж байгаа нь төсвийг зөрүүтэй төлөвлөх үндэслэл болж байна.	13
2.2 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд орлого эх үүсвэрийг бодитой бүртгэж тайлагнасан байна.	14
2.3 Батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан байна.	15
2.4 Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна.	17
2.5 Төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, агуулахын эмх цэгц, хөрөнгийн тооллого, тооцоо бодолт хангалтгүй байна.	18
БҮЛЭГ В. Дотоод хяналт шалгалт үр нөлөөтэй хэрэгжиж чадахгүй байна.	19
3.1 Өдөр тутмын үйл ажиллагаанд тавьж байгаа дотоод хяналт сул байна.	19
3.2 Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс 5 жил тутамд магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийгдсэн байна.	20
3.3 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдад олгох тэтгэлгийг журмын дагуу олгож, олон нийтэд ил тод мэдээлсэн байна.	21
3.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.	21
ДҮГНЭЛТ:	22
ЗӨВЛӨМЖ:	23
Холбогдох байгууллагын санал	24

Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний Зөвлөл
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
МБЭСБ	Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НХМ	Нэг хэвийн маягт
ОУБ	Олон улсын байгууллага
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах орон
ПК	Политехникийн коллеж
ХАА	Хөдөө аж ахуй
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХАА	Хүнс, хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭСЯ	Элчин сайдын яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймаг дахь Төрийн аудитын газрын өөрийн санаачилгаар 2021 оны аудитын болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Монгол улсын Ерөнхий аудиторын А/28 дугаар "Аудитын төлөвлөгөө батлах тухай" тушаалын дагуу аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	МСҮТ-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга болон МСҮТ-ийн удирдлагуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Мэргэжлийн боловсролын сургалт нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх? - Хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүнтэй эсэх? - Дотоод хяналт шалгалт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад МСҮТ-ийн 2019, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, байгууллагын үндсэн ба туслах үйл ажиллагааны орлого, гэрээ хэлцэл, оюутны дадлага, тэтгэлэгтэй холбоотой гэрээ хэлцэл, санхүүгийн анхан шатны баримт, хөрөнгийн тооллого тооцоо бодолт, өр авлагын тооцоо нийлсэн акт баримтыг хамрууллаа. Аудитаар Заамар, Зуунмод, Эрдэнэ сум дахь МСҮТ, Баянчандмань сум дахь Политехникийн коллежийн үйл ажиллагаатай танилцаж, тулган баталгаажуулалтыг хийсэн.
Аудитын хязгаарлалт	Байхгүй.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. • Төрийн аудитын тухай хууль • Төсвийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль • Боловсролын тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль • Шилэн дансны тухай хууль

- Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам 2018 он
- "MNS6541:2015, мэргэжлийн боловсролын сургалт, Ерөнхий шаардлага" Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 45 дугаар тогтоол
- "Журам батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны а/50 дугаар тушаал
- ЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай",
- Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, НББ-д тусгах, хяналт тавих" журам
- Засгийн газрын 2011.11.09-ний 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"
- Тухайн хичээлийн жилд мөрдөх дүрэм журам
- Бусад холбогдох судалгаа, баримт материал

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Саранчимэг, аудитор Ж.Бямбацогт, Д.Бямбасүрэн, Г.Баянжаргал, Т.Хүрэлбаатар нар гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2021 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, гүйцэтгэлийн буюу талбарын ажлыг 2021 оны 5 дугаар сарын 19-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг нэгтгэн боловсруулж, анхан шатны болон хоёр дахь шатны хяналтаар хянуулан, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр байгууллагын удирдлагад хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорионы дэглэм тогтоосон нь аудитад хамрагдагч байгууллагуудын албан хаагчид ээлжээр болон гэрээр ажиллаж байсан тул шаардлагатай баримт материал, судалгаа мэдээлэл авахад цаг алдах хүндрэл бэрхшээлтэй байлаа.

БҮЛЭГ А. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалт нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

1.1 Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудад холбогдох хууль, эрх зүйн орчин бүрдэж, орон нутагт үр дүнтэй хэрэгжиж байна.

Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй МБЭСБ-ууд нь Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Сургалтын байгууллага хүмүүнлэг, ардчилсан зарчим, эрх зүйн орчинд суурилсан засаглал, бүтэц зохион байгуулалттай байх бөгөөд түүгээрээ дамжуулан алсын хараа, эрхэм зорилго, зорилт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, тогтмол хянах, үнэлэх, сургалтыг тасралтгүй чанаржуулах эрэлт, шаардлагыг хангаж ажилладаг байна.

Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын бодлого зохицуулалтын газраас батлагдсан квотын дагуу ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Баянчандмань суман дахь Политехникийн коллеж нь 2,5 жилийн мэргэжлийн боловсролын сургалтаар 9, 1 жилийн сургалтаар 8, 21-45 хоногийн түр сургалтаар 1 мэргэжил,
- Төв аймаг дахь МСҮТ нь 2,5 жил буюу мэргэжлийн боловсролын сургалтаар 8, 1 жилийн сургалтаар 13, 21-45 хоногийн түр сургалтаар 3 мэргэжил,
- Эрдэнэ сум дахь МСҮТ нь 2,5 жил буюу мэргэжлийн боловсролын сургалтаар 7, 1 жилийн сургалтаар 11, 21-45 хоногийн түр сургалтаар 3 мэргэжил,
- Заамар сум дахь МСҮТ нь 2,5 жил буюу мэргэжлийн боловсролын сургалтаар 5, 1 жилийн сургалтаар 14, 21-45 хоногийн түр сургалтаар 6 мэргэжлийн чиглэлээр сургах тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагууд дараах эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/187 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ын дагуу элсэлтийг зохион байгуулж жил бүр хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн элсэлтийн саналаа гаргаж орон нутгийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн ХНХЯ-д хүргүүлж батлуулан ажилласан байна.
- ✓ БСШУ сайд, ХНХЯ сайдын хамтарсан 2019 оны А/324 дүгээр, А/690 дугаар тушаалын Мэргэжлийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний загвар батлах тухай, ХНХЯ сайдын А/159 дүгээр тушаалаар батлагдсаны дагуу удирдлага болгон боловсруулж Мэргэжлийн боловсрол сургалтын бодлого, зохицуулалтын газрын даргаар баталгаажуулсан сургалтын төлөвлөгөөг мөрдөж ажилласан байна.
- ✓ Засгийн газрын 2020 оны 44 дүгээр тогтоол Мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам

- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/127 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”
- ✓ Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/50 тоот тушаал “Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам” мөрдөж төгсөлтийн үнэлгээг зохион байгуулсан байна.
- ✓ Сангийн сайд, ХНХЯ-ны сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 289, А/375 дугаар тушаалаар МБСБ-ын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журмаар Багшийн цагийн ачааллыг тооцсон байна.

1.2 Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагууд зорилго, зорилтдоо нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино” гэж заасан байна

Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалт нь тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн иргэдийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг агуулдаг байна.

Сургалтын байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг, техник мэргэжлийн боловсрол, сургалтын олон улсын хөгжлийн чиг хандлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн оновчтой тодорхойлж баталгаажуулан, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлж дүгнэх, сургуулийн байнгын, тогтвортой ажиллагааг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, “Монгол Улсын Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024”, “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр 2016-2021” зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн судалгаа шинжилгээ, инновац, мэдээллийн технологид суурилсан “Чанартай сургалт-тогтвортой хөдөлмөр эрхлэлт” хэмээн зорилгоо тодорхойлсон байна.

Энэхүү зорилго зорилтоо хэрэгжүүлэхээр стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг ногоон хөгжлийн бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлж, сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох замаар мэргэжил эзэмшилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2. МБЭСБ-ын ажилтан, албан хаагч, суралцагчдын эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг дэмжих, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг үе шаттай бүрдүүлнэ.
3. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, нийгмийн түншлэл, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
4. Мэргэжлийн боловсрол, сургалтын цахим сургалтын платформ, бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, сургуулийн санхүүжилт, өөрийн орлогын бүрдүүлэлт, ашиглалтын оновчтой хэлбэрийг тогтоож мөрдүүлнэ.

2020 онд Баянчандмань сум дахь Политехникийн коллеж нь 11 зорилтын хүрээнд 37 бүлгийн 80 арга хэмжээг, Төв аймаг дахь МСҮТ нь 28 зорилт 85 арга хэмжээг, Заамар сум дахь МСҮТ нь 7 зорилтын хүрээнд 38 бүлгийн 64 арга хэмжээг, Эрдэнэ сум дахь МСҮТ 38 зорилт 75 арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Баянчандмань сум дахь Политехникийн коллеж, Төв аймаг, Эрдэнэ сум, Заамар сум дахь МСҮТ-үүд нь Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайдтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гаргаж тайлагнасан боловч, тайланг дүгнэж, албажуулаагүй байна.


1.3 2017-2020 оны нийт төгсөгчдийн 54,4 хувь нь ажлын байраар хангагдсан байна.

Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагууд нь ХНХС-ын тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу үйл ажиллагааг явуулж байна.

Баянчандмань сум дахь Политехникийн коллеж болон Төв, Заамар, Эрдэнэ сум дахь МСҮТ-ээс ирүүлсэн судалгаагаар 2020 оны байдлаар нийт 241 ажиллагсад ажиллаж байна.

Багш, ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллаж буй байдалд судалгаа хийхэд 28 буюу 11,6 хувь нь 1 хүртэл, 54 буюу 22,4 хувь нь 1-5 жил, 51 буюу 21,2 хувь нь 6-10 жил, 48 буюу 19,9 хувь нь 11-15 жил, 23 буюу 9,5 хувь нь 16-20 жил, 19 буюу 7,9 хувь нь 21-25 жил, 18 буюу 7,5 хувь нь 25-аас дээш жил ажиллаж байна. Нийт ажиллагсдын 44,8 хувь нь 10-аас дээш жил ажиллаж байна.

График №1 Ажиллагсдын ажилласан жилийн судалгааг графикаар харуулав.



Эх сурвалж: Аудитын явцад ирүүлсэн судалгааны мэдээлэл

Нийт ажиллагсдын 106 буюу 44.0 хувийг багш нар, 126 буюу 52,3 хувийг бусад ажиллагсад, 9 буюу 3,7 хувийг захирал, эрхлэгч менежер эзэлж байна.

Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудын багш нарыг боловсролын байдал, зэрэг дэв олгосон байдлыг авч үзэхэд:

- Төв аймаг дахь МСҮТ-д сургалтын менежер-1, арга зүйч багш-2, ерөнхий эрдмийн багш-8, мэргэжлийн багш-14 нийт 22 багш ажиллаж байна. Үүнээс: магистр зэрэгтэй-8, бакалавр зэрэгтэй-12, дипломын зэрэгтэй-2, зөвлөх багш-2, тэргүүлэх багш-9, заах арга зүйч багш-4 ажиллаж нийт багш нарын 68,2 хувь нь зэрэгтэй байна.
- Эрдэнэ сум дахь МСҮТ-д сургалтын менежер-1, нийгмийн ажилтан-1, номын санч-1, дотуур байрны багш-1, мэргэжлийн-16, ерөнхий эрдмийн-8 багш ажиллаж байна. Үүнээс: магистр-2, арга зүйч багш-3, тэргүүлэх багш-4, зөвлөх багш-1 ажиллаж нийт багш нарын 50,0 хувь нь зэрэгтэй байна.
- Заамар сум дахь МСҮТ-д сургалтын менежер-1, нийгмийн ажилтан-1, дотуур байрны багш-3, багш 24 ажиллаж байна. Үүнээс магистр-4, бакалавр-22, диплом-2, заах арга зүйч-3, тэргүүлэх-4, зөвлөх-1 нийт багш нарын 33,3 хувь нь зэрэгтэй байна.
- Баянчандмань сум дахь Политехникийн коллежд сургалтын менежер-1, нийгмийн ажилтан-1, номын санч-1, дотуур байрны багш-3, мэргэжлийн-20, ерөнхий эрдмийн-15 багш ажиллаж байна. Үүнээс магистр-21, арга зүйч-15, тэргүүлэх-8 нийт багш нарын 65,7 хувь нь зэрэгтэй байна.

Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудын сургалтын орчин сайжирч, элсэн суралцагсдын тоо Засгийн газраас тэтгэлэг олгодог болсон болон тухайн жилийн элсэлтийн хяналтын тоонд багтаан ажиллаж байгаатай холбоотойгоор сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна. Тухайлбал:

Төв аймаг дахь МСҮТ-ийн элсэн суралцагсад 2017 онд 196 байсан бол 2020 онд 262, Эрдэнэ сум дахь МСҮТ-ийн элсэн суралцагсад 2017 онд 123 байсан бол 2020 онд 224, Баянчандмань сум дахь Политехникийн коллежид элсэн суралцагсад 2017 онд 116 байсан бол 2020 онд 219, Заамар сум дахь МСҮТ-ийн элсэн суралцагсад 2017 онд 221 байсан бол 2020 онд 281 болж өссөн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд 2017 онд нийт 656 суралцагч шинээр элсэн суралцаж байсан бол 2020 онд 986 болж, 330 суралцагчаар буюу 33,5 хувиар өссөн байна. Үүнд: Эрдэнэ, Баянчандмань сумын МСҮТ-д элсэн суралцагсад 101-103 суралцагчаар буюу 45,1-47,0 хувиар өссөн байна.

Мөн элсэн суралцагсад, төгсөгчдийн тоон үзүүлэлтийг 2017-2020 оноор авч үзэхэд нийт 3468 суралцагч элсэн суралцсанаас, 3060 буюу 88,2 хувь төгссөн байна. Нийт төгсөгчдийн 1649 буюу 53,9 хувь нь ажлын байраар хангагдсан үзүүлэлттэй байна. Судалгааг нэгтгэн хүснэгтээр харуулав.

Хүснэгт №1 МСҮТ-ийн элсэгчид, төгсөгчдийн 2017-2020 оны судалгаа

Үзүүлэлт	Элсэн суралцагсад				Нийт төгсөгчид				Үүнээс Ажлын байраар хангагдсан төгсөгчид			
	2017	2018	2019	2020	2017	2018	2019	2020	2017	2018	2019	2020
Төв аймаг дахь МСҮТ	196	212	243	262	196	212	243	262	96	124	134	146

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, үр дүн												
Эрдэнэ сум дахь МСҮТ	123	155	215	224	204	186	124	156	76	88	84	89
Баянчандмань сум дахь Политехникийн коллеж	116	278	270	219	205	259	145	165	91	162	81	95
Заамар сум дахь МСҮТ	221	236	217	281	149	154	163	237	66	67	81	169
Нийт дүн	656	881	945	986	754	811	675	820	329	441	380	499
		3468				3060				1649		

Эх сурвалж: Аудитын явцад ирүүлсэн судалгааны мэдээлэл

2017-2018 оны хичээлийн жилийн нийт суралцагчдын тоо нийт төгсөгчдийн тооноос өссөн байгаа нь 1 жилийн ангиудын элсэгчдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой байна.

МБЭСБ нь суралцагч, төгсөгчдийн ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүнд суралцагч төгсөгчдийн ур чадвар дээшилж орон нутгийн болон улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцдог байна. Үүнд:

- Баянчандмань сум дахь Политехникийн коллеж нь Багшийн хөгжлийг дэмжих, багш суралцагчдын ая тухтай орчинд ажиллаж суралцах чанартай сургалт, чадавхтай багш, чадамжтай төгсөгч гэсэн урианы дор “Авто, ХАА-н чадварлаг мэргэжилтэн бэлтгэх” алсын хараатайгаар төгсөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэн ажилласан байна. Үүнд: Автомашины засварчин мэргэжлээр бүсэд 2017-2018 онд 1-р байр, улсад 2-р байр, тогооч мэргэжлээр 2017 онд 1-р байр, 2018 онд 3-р байр, 2019 онд 3-р байр, ХАА газар тариалангийн улсын уралдаанд 2, 3 байр эзэлсэн амжилтуудыг үзүүлсэн байна.
- Төв аймаг дахь МСҮТ нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Шилийн гол, Хянган аймгийн ажил мэргэжлийн дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээтэй ажилласнаар Гагнуур, Цахилгаанчин, Компьютер, Тогооч, Хүлэмжийн аж ахуй, Малчин мэргэжлээр багш, оюутан солилцоог амжилттай зохион байгуулсан байна. 2020-2021 оны хичээлийн жилд Химийн улсын XVI олимпиадад хими биологийн багш тэргүүн байр эзэлж, түүний бэлтгэсэн цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан мэргэжлийн суралцагч 2-р байр, үсчний мэргэжлийн ангийн суралцагч 3-р байр, Улсын физикийн XVII олимпиадад физик, газар зүйн багш 5-байр, Монгол хэлний улсын XV олимпиадад тогооч мэргэжлийн ангийн суралцагч тэргүүн байр, математикийн улсын XVIII олимпиадад үсчний мэргэжлийн ангийн 2 суралцагч 3, 6-р байр тус тус эзэлсэн байна. “Монгол ур чадвар-2020” уралдаанд тогоочийн мэргэжлийн 3-р ангийн суралцагч 3-р байрт буюу 1-р шатны ялагчаар шалгарсан байна.
- Эрдэнэ сум дахь МСҮТ нь 2019 онд малчны ангийг монгол ахуйгаар тохижуулах төлөвлөгөө гарган тохижуулсан байна.

1.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын материаллаг орчин бүрдэж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр харилцан адилгүй хангагдсан байна.

Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх салбарын шинэчлэл нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер техникийн ажилтны түвшинд хүргэж чадваржуулах,

үйлдвэрлэл-дадлагын сургалтын бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх тодорхой ажлуудыг хийсэн байна. Тухайлбал:

- Төв аймаг дахь МСҮТ нь сургалтын орчин, материаллаг баазын хүчин чадлыг нэмэгдүүлэх, оюутан, сурагчдын нийгмийн хамгааллын баталгааг хангасан ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2019-2020 оны хичээлийн жилд орон нутгийн санхүүжилтээр спорт заал, хөгжмийн техник хэрэгслийг 20.0 сая төгрөгөөр, 2020-2021 оны хичээлийн жилд МБСБ-ыг дэмжих орон нутгийн санхүүжилтээр хими, физикийн лабораторийг 20.0 сая төгрөгөөр, Жайка ОУБ-ын төсөл хөтөлбөрөөр 2016-2019 онд тогооч нарийн боовны мэргэжлийн тоног төхөөрөмж, дадлагын газрыг 32.2 сая төгрөгөөр, 2018-2019 онд үсчин мэргэжлийн ном, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнийг 3.8 сая төгрөгөөр бэлтгэсэн байна.

Мөн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 2019-2020 онд хичээлийн байр болон дотуур байрны 00-ын засварын шинэчлэл, хичээлийн байрны анги танхим, өрөө тасалгааны засварын шинэчлэл, 2020-2021 онд дотуур байрны өрөө тасалгаанд 50 ширхэг давхар ор, хичээлийн 3 анги танхимд 30 ширхэг ширээ сандал хийсэн, хичээлийн байрны 1 ба 2 давхарт багш, ажилчдын бүтээлч санаачилгаар 40 ширхэг цэцэг үрслүүлж эко орчныг бүрдүүлсэн. Тус хамт олон 2021-2022 оны хичээлийн жилд “Төв аймаг дахь Политехник коллеж” болох томоохон зорилтыг тавин ажиллаж байна.

- Эрдэнэ сум дахь МСҮТ нь 2019 онд “Мах боловсруулах үйлдвэрийн ажилтан”-ны ангийн их засварт шаардлагатай 23.1 сая төгрөгийг ХНХЯ-аар шийдвэрлүүлэн Европын холбоо, НҮБ-ын ХХАА-н байгууллагаас хэрэгжүүлж буй “SECIM-2” төслөөс 62.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн, заалны дотоод засал чимэглэлийг 10.0 сая төгрөгөөр гүйцэтгэн, Соёлын төвийн хөгжим апартурыг 7.0 сая төгрөгөөр шинэчилсэн байна.

2020 онд багш, ажиллагсдын амрах өрөөг 2.4 сая төгрөгөөр шинэчлэн засварлаж, үндэсний хэмжээний сургалтуудыг зохион явуулах 0.66 сая төгрөгийн өртөгтэй интернэтийн хурдыг 2 дахин нэмэгдүүлсэн, 3ш WI-FI төхөөрөмжүүдийг сургуулийн орчинд байршуулсан. ХНХЯ-ны хөрөнгө оруулалтаар 30.0 сая төгрөгийн дотуур байрны тоног төхөөрөмжийг шинэчлэн суралцагсдын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн байна.

Мөн ерөнхий эрдмийн ангиудыг тохижуулж, сургалтын орчныг сайжруулан онлайн болон теле хичээл явуулах боломжоор бүрэн хангаж, бүх анги интернэттэй холбогдож дэвшилтэт технологит суралцах нөхцөлийг бүрдүүлэн, ерөнхийн эрдмийн онол болон лабораторийн танхим тохижуулахад Төв аймгийн Засаг даргын нөөц сангаас 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж өгч сургалтын баазыг сайжруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдад зориулсан гарц, шат, давхар бүрд бие засах газрыг тусгайлан бэлтгэж ашиглалтад оруулж, нийгэм, соёлын ажилтны өрөөнд 0.6 сая төгрөгөөр, газар зүй, биологи, математик, мэдээлэл зүйн ангийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан 5.2 сая төгрөгөөр урсгал засвар хийн тохижуулсан.

Чех улсын ЭСЯ-аас жил бүр зарлагддаг “Орон нутгийг дэмжих” төсөлд 3 дахь жилдээ хамрагдан “Мал төхөөрөх жижиг цех”-ийн 42.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн байршуулж, ашиглалтгүй байсан конторын барилгыг 22.6 сая төгрөгөөр засварлан тохижуулж, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн мэргэжлийн боловсролын байгууллага болсон байна.

- Заамар сум дахь МСҮТ-ийн хувьд сүүлийн жилүүдэд томоохон төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт хийгдээгүй учир сургалтын орчин төдийлөн сайжраагүй байна. Энэ нь ашиглалтад орсноос хойш сургуулийн хичээлийн байр, дотуур байранд их засвар ороогүйн улмаас барилгын дээврийн хар цаас элэгдэж зун дээврээс ус гоожих, хана муудаж хөгцөрч өвөлдөө хүйтэн байдаг байна. Иймд өөрсдийн нөөц бололцоогоор дотуур байранд болон хичээлийн байранд дотоод засал, хуучирсан модон цонхыг шинэчлэх зэрэг ажлыг хийсэн байна.

2020 онд Төв аймгийн орон нутгийн төсвөөс Англи хэлний лингафоны танхимын тоног төхөөрөмж 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Мөн мэргэжил бүр дээр сургалтын материаллаг орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж харилцан адилгүй хангагдсан нь сүүлийн үеийн дэвшилтэт технологийг сурагчдад дадлагын сургалтаар олгоход хүндрэлтэй болсон байна. Жишээ нь: Хүнд машин механизмын оператор мэргэжлийн симулятор гэхэд доод тал нь 9.0-10.0 сая төгрөг байдаг тул дадлагын сургалт төдийлөн үр дүнгүй болдог байна.

Ажил олгогчийн захиалгаар сурч байгаа суралцагчдын хувьд ажлын байран дээр нь очиж дадлага сургуулилт хийдэг тул техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагддаг байна.

- Баянчандмань сум дахь Политехникийн коллеж нь Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжсэн, ХНХЯ-ны дэргэд хэрэгжиж буй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хөрөнгө оруулалтаар нийт 3,355.0 сая төгрөгийн ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1. Ноос ноолуур, Хүнсний ногооны фермер, Хүлэмжийн аж ахуйн фермер 1,164.2 сая төгрөгөөр,
2. ХАА-н тоног төхөөрөмж, ойжуулагч тоног төхөөрөмж, Авто засвар, кузов засварын тоног төхөөрөмж 314.5 сая төгрөгөөр,
3. Мэдээллийн IT –ийн тоног төхөөрөмж 29.4 сая төгрөгөөр,
4. Сургуулийн болон агро паркийн орчинд хийгдсэн барилгын ажлуудыг 1,846.9 сая төгрөгөөр

Мөн аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хими биологийн кабинетэд 20.6 сая төгрөгийн сургалтын лабораторийн тоног төхөөрөмж хэрэгслийг бэлтгэж тохижуулсан байна.

Мэргэжлийн болон ерөнхий эрдмийн багш нарын ажиллах ая тухтай орчин бүрдүүлж “Багш хөгжлийн төв”-ийг бий болгож төсвийн хөрөнгөөр тохижуулсан байна.

Баянчандмань суман дахь Политехникийн коллеж тоног төхөөрөмжүүд.



БҮЛЭГ Б Хөрөнгийн тооллого, тооцоо бодолт хангалтгүй, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.

2.1 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төсвийн төсөлд өгсөн саналыг өөрчлөн баталж байгаа нь төсвийг зөрүүтэй төлөвлөх үндэслэл болж байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд болон Политехник коллежийн 2019-2020 оны төсвийн төсөлд хүргүүлсэн санал өөрчлөгдөн батлагдсан байна. Энэ нь анхан шатны мэдээлэлд тулгуурлан тооцсон дүнг нэмэгдүүлж болон бууруулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг зөрүүтэй төлөвлөх үндэслэл болж байна. 2019-2020 оны төсвийн төсөлд өгсөн санал, батлагдсан төсвийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №2 2019-2020 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв /сая төгрөг/

Мэргэжлийн сургуулиуд	2019			2020			Батлагдсан төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулбал
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Нэмэгдсэн хасагдсан	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Нэмэгдсэн хасагдсан	
Эрдэнэ сум дахь МСҮТ	938.9	917.5	(21.4)	1,081.9	1,120.1	38.2	202.6
Заамар сум дахь МСҮТ	794.5	927.4	132.9	1,095.7	1,052.7	(43.0)	125.3
Төв аймаг дахь МСҮТ	1,050.7	1,247.7	197.0	1,411.1	1,402.4	(8.7)	154.7
Баянчандмань суман дахь ПК	1,620.3	1,857.1	236.8	2,079.4	2,207.4	128.0	350.3
Нийт дүн	4,404.4	4,949.7	545.3	5,668.1	5,782.6	114.5	832.9

- Эрдэнэ сум дахь МСҮТ нь:
 - ✓ 2019 оны төсвийн төсөлд 938.9 сая төгрөгийн санал хүргүүлснээс 1 хөтөлбөр 3 арга хэмжээнд 917.5 сая төгрөг буюу 21.4 сая төгрөгөөр бууруулан батлагдсан байна.
 - ✓ 2020 оны төсвийн төсөлд 1,081.9 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн саналыг 38.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1

хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,120.1 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

- Төв аймаг дахь МСҮТ нь:
 - ✓ 2019 оны төсвийн төсөлд 1,050.7 сая төгрөгийн санал хүргүүлснээс 1 хөтөлбөр 3 арга хэмжээнд 1,247.7 сая төгрөг буюу 197.0 сая төгрөгөөр нэмж батлагдсан байна.
 - ✓ 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,411.1 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 8.7 сая төгрөгөөр бууруулан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,402.4 сая төгрөгөөр батласан байна.
- Заамар сум дахь МСҮТ нь:
 - ✓ 2019 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 794.5 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 132.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 927.4 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.
 - ✓ 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,095.7 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 42.9 сая төгрөгөөр бууруулан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,052.7 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна. 2020 онд төсвийг 3 удаа тодотгол хийгдэж, 10 дугаар сард 1,011.6 сая төгрөгөөр тогтоосон байна.
- Баянчандмань суман дахь Политехник коллеж нь
 - ✓ 2019 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,620.3 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 236.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,857.1 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.
 - ✓ 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,079.4 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 128.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,207.4 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн 2020 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулбал Эрдэнэ сум дахь МСҮТ 202.6 сая төгрөг, Заамар сум дахь МСҮТ 125.3 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 154.7 сая төгрөг, Баянчандмань сум дахь Политехникийн коллеж 350.3 сая төгрөг нийт 832.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 472 тогтоолоор төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлсэн учир үндсэн цалин, НДШ болон Covid19 цар тахал улам бүр нэмэгдэж байсан тул ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал, нормын хувцас гэх зардлуудыг нэмэгдүүлэн баталсан байна.

2.2 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд орлого эх үүсвэрийг бодитой бүртгэж, бүрэн тайлагнасан байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн 2019 онд мөнгөн гүйлгээний тайлангаар улсын төсвөөс 4,920.2 сая төгрөгийн урсгал санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 8.3 сая төгрөг, туслах аж ахуйн орлого 23.0 сая төгрөг, хандив тусламжийн орлого 34.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 37.7 сая төгрөг нийт 5,024.1 сая төгрөг, үр дүнгийн тайлангаар улсын төсвөөс 4,920.2 сая төгрөгийн урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого 27.7 сая төгрөг, үнэ төлбөргүй

хүлээн авсан орлого 256.8 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 19.5 сая төгрөг, тусламжийн орлого 45.5 сая төгрөг нийт 5,269.7 сая төгрөг тус тус тайлагнажээ.

Мөн 2020 онд мөнгөн гүйлгээний тайлангаар улсын төсвөөс 5,709.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 0.3 сая төгрөг, туслах аж ахуйн орлого 23.3 сая төгрөг, оюутнуудын хоол, оёдлын орлогоос 3.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 10.1 сая төгрөг нийт 5,746.1 сая төгрөг, үр дүнгийн тайлангаар улсын төсвөөс 5,709.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого 10.1 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,574.3 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 11.8 сая төгрөг нийт 7,305.5 сая төгрөг тус тус тайлагнасан байна.

Хүснэгт №3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн 2019,2020 оны орлого эх үүсвэрийг бүртгэж тайлагнасан байдал / сая төгрөг/

Тайлагнал	Тайлант он	2019				2020			
	МБС-иуд	Эрдэнэ сум дахь МСҮТ	Заамар сум дахь МСҮТ	Төв аймаг дахь МСҮТ	Баянчандмань сум дахь МСҮТ	Эрдэнэ сум дахь МСҮТ	Заамар сум дахь МСҮТ	Төв аймаг дахь МСҮТ	Баянчандмань сум дахь МСҮТ
Мөнгөн гүйлгээний тайлангаар	Улсын төсвөөс урсгал санхүүжилт	910.0	919.3	1247.7	1843.1	1111.6	1003.1	1401.3	2193.4
	Үндсэн үйл ажиллагааны орлого	6.9		0.8	0.6				0.3
	Туслах үйл ажиллагааны орлого		8.2		14.9	0.3	8.6		14.4
	Оюутнуудын хоол, оёдлын орлогоос					1.8		1.2	
	Хандив тусламжийн орлого				34.9				
	Нэмэлт санхүүжилтийн орлого	2.1	24.1	1.5	10.0	0.2	6.4	3.5	
	Нийт тайлагнасан орлого	919.0	951.6	1,250.0	1,903.6	1,113.9	1,018.2	1,405.9	2,208.1
Үр дүнгийн тайлангаар	Улсын төсвөөс урсгал санхүүжилт	910.0	919.3	1247.7	1843.1	1111.6	1003.1	1401.3	2193.4
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8.0	10.7	0.8		2.1	8.5	1.2	
	Тусламжийн орлого		45.5						
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93.7	1.5	58.3	103.3	117.8	47.5	37.1	1371.9
	Нэмэлт санхүүжилтийн орлого	2.1	24.1	1.5		0.2	6.4	3.5	
	Нийт тайлагнасан орлого	1,013.9	1,001.1	1,308.3	1,946.4	1,231.6	1,065.5	1,443.0	3,565.3

Эх сурвалж: 2019, 2020 оны санхүүгийн тайлангаас.

2.3 Батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2020 онд батлагдсан төлөвлөгөөгөөр Эрдэнэ сум дахь МСҮТ 1,120.1 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 1,402.4 сая төгрөг, Заамар сум дахь МСҮТ 1,011.6 сая төгрөг, Баянчандмань суман дахь Политехник коллеж 2,207.4 сая төгрөг тус тус батлагдсан байна.

Тайланд онд гүйцэтгэлээр Эрдэнэ сум дахь МСҮТ 1,113.7 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 1,339.7 сая төгрөг, Заамар сум дахь МСҮТ 898.7 сая төгрөг, Баянчандмань суман дахь Политехник коллеж 2,084.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2020 онд батлагдсан төсөвт зардлыг Эрдэнэ сум дахь МСҮТ 6.4 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 62.7 сая төгрөг, Заамар сум дахь МСҮТ 112.9 сая төгрөг,

Баянчандмань суман дахь Политехник коллеж 122.6 сая төгрөгийг тус тус хэмнэж улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Энэ нь дараах шалтгааны улмаас хэмнэгдсэн байна. Үүнд:

- ❖ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд нь Covid19 цар тахлаас үүдэн багш, тогооч, дотуур байрны жижүүр нарт илүү цагийн нэмэгдэл, кредит цагийн хөлсийг 3-9 сар хүртэл олгоогүй,
- ❖ 2020 оны 02 дугаар сараас эхлэн байрны хүүхдүүд хичээл цахимаар хичээллэж, дотуур байранд хүүхдүүд байрлаагүйгээс хоолны зардал хэмнэгдэж үлдэгдэлтэй байсан зэрэг шалтгаанаар хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №4 2019-2020 оны төсвийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Мэргэжлийн сургуулиуд	2019			2020		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Татан төвлөрүүлсэн	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Татан төвлөрүүлсэн
Эрдэнэ сум дахь МСҮТ	917.5	869.8	(47.7)	1,120.1	1,113.7	(6.4)
Заамар сум дахь МСҮТ	927.4	858	(69.4)	1,011.6	898.7	(112.9)
Төв аймаг дахь МСҮТ	1,247.7	1219.9	(27.8)	1,402.4	1,339.7	(62.7)
Баянчандмань суман дахь ПК	1,857.1	1,837.2	(19.9)	2,207.4	2,084.8	(122.6)
Нийт дүн	4,949.7	4,784.9	(164.8)	5,741.5	5,436.9	(304.6)

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн 2019, 2020 оны батлагдсан төсвийн зарцуулаагүй дараах үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- 2019 онд Эрдэнэ сум дахь МСҮТ 47.7 сая төгрөг, Заамар сум дахь МСҮТ 69.4 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 27.8 сая төгрөг, Баянчандмань сум дахь Политехникийн коллеж 19.9 сая төгрөг
- 2020 онд Эрдэнэ сум дахь МСҮТ 6.4 сая төгрөг, Заамар сум дахь МСҮТ 112.9 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 62.7 сая төгрөг, Баянчандмань сум дахь Политехникийн коллеж 122.6 сая төгрөг

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд нь батлагдсан төсвийн хөрөнгийг зарцуулахдаа цалин давхардуулан олгосон, цалингийн сангаас шагнаж урамшуулсан, үр дүнгийн урамшуулал, үр чадварын нэмэгдэл зэргийг хавтгайруулан олгосон, хичээл практикийн зардлыг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Эрдэнэ сум дахь МСҮТ 2020 онд оюутнуудын мэргэжлийн дадлага хийх 13.6 сая төгрөгөөр анги танхим засварлаж тохижуулсан, захирлын тушаалаар 3.6 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон, мөн цалингийн сангаас багш, ажилтан нарыг шагнаж урамшуулан 10.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.
- Төв аймаг дахь МСҮТ 2020 оны жилийн эцэст НДШ, ХАОАТ-ын тайлан тооцоо нийлээгүйгээс 4.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, захирлын тушаалаар мэдлэг мэргэжлээ дээшлүүлж, зэрэг дэв ахисан албан хаагчдыг цалингийн зардлаас үндсэн цалингийн 40 хувиар давхардуулан урамшуулсан, магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хэсэг болон дэд ажлын хэсгийн ажлыг жилийн эцэст дүгнэж, мөн жилийн эцсийн ажил үүргийг дүгнэн үр дүнгийн гэрээний урамшуулалтай давхардуулан олгосон, төсвөөс оюутнуудын мэргэжлийн дадлага хийх 26.1 сая төгрөгийн зардалд зарцуулсан дадлагын тайлан баримт үдэж архивлаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байсан.

- 2020 онд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтаны шийдвэр гараагүй байхад Эрдэнэ сум дахь МСҮТ-ийн захирал 0.7 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ-ийн захирал 2.2 сая төгрөгийн урамшуулал авсан.
- Заамар сум дахь МСҮТ нь мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, тасаг нэгжийн нэмэгдэл олгохдоо багш нарт тооцож олгосон багц цагт олгож байгаа нэмэгдэл, ур чадварын нэмэгдлийг дүгнэсэн шалгуур үзүүлэлтүүд, ажлын үр дүн, ажлын хэсгийн үнэлэлт ижил, олгож байгаа нэмэгдлүүд давхацсан хэт хавтгайрсан байдалтай, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 жилийн тэтгэмжид 2019 онд 5 хүнд 29.1 сая төгрөгийг олгох шийдвэр гаргаагүй байхад олгосон.
- Баянчандмань суман дахь Политехник коллеж нь 2020 онд багш, ажилчдад 17.5 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон, суралцагчдын хоолны зардлаас 2.4 сая төгрөгийг сургуулийн засвар хийсэн албан хаагчдад зарцуулсан, оюутнуудын мэргэжлийн дадлага хийж тариалсан ногоон тэжээлээс 1290 боодол тэжээлийг орлогод авалгүй зарцуулсан.

2.4 Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд 2019, 2020 онд батлагдсан төсөв болон ХНХЯ-ын хөрөнгө оруулалтаас гадна Бүгд найрамдах Чех улсын хөдөө аж ахуй төсөл, Германы олон улсын хамтын ажиллагааны GIZ-ийн төсөл, Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжсэн ХНХЯ-ны дэргэд хэрэгжиж буй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төсөл, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, сум орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс хандивласан хөрөнгө зэрэг эх үүсвэрүүдээс хөрөнгө оруулалт хийгдсэн байна. 2019 онд нийт 227.1 сая төгрөг, 2020 онд 3,529.6 сая төгрөг, нийт 3,756.7 сая төгрөгийн төсөл, хөтөлбөр хэрэгжиж мэргэжлийн сургалтыг олгох сургалтын орчин бүрдүүлэн ажилласан байна.

Хүснэгт №5 2019-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн судалгаа

№	Хөрөнгө оруулалт хийсэн байгууллага	Эрдэнэ МСҮТ		Заамар сум дахь МСҮТ		Төв аймаг дахь МСҮТ		Баянчандмань Политехникийн коллеж	
		2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	23.1	37.2	45.2	19.5	46.6	12.6		
2	Азийн хөгжлийн банкны төсөл							42.3	3,355.0
3	НҮБ-ийн ХХАА-ын байгууллага	62.0							
4	БНЧУ-ын хөдөө аж ахуй төсөл		44.3						
5	Германы олон улсын хамтын ажиллагааны GIZ-ийн төсөл		2.7						
6	Аймаг, орон нутгаас		19.0		19.7		19.7		
7	Аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс			7.9					
		85.1	103.2	53.1	39.2	46.6	32.3	42.3	3,355.0

Эх сурвалж: 2019, 2020 оны санхүүгийн тайлангаас

2.5 Төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, агуулахын эмх цэгц, хөрөнгийн тооллого, тооцоо бодолт хангалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч хөрөнгийн тооцоо бодоогүй, НХМ БМ-8 маягтыг хөтлөөгүй, тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярвыг оруулсан нийтлэг зөрчлүүд илэрлээ. Аудитын явцад хяналтын тооллого хийхэд Баянчандмань сум дахь Политехник коллежийн Аксент маркийн автомашин, Портер ачааны автомашин, Асио автобус тус тус дутагдсан, Заамар, Эрдэнэ сум дахь болон Төв аймаг дахь МСҮТ-үүдийн хүнсний материалын үлдэгдэл зөрүүтэй зөрчил илэрсэн.

Аудитын илрүүлэлт:

- Эрдэнэ сум дахь МСҮТ 2020 оны жилийн эцсийн тооллого хийж 1,957.6 сая төгрөгийн хөрөнгийн тооцоо бодоогүй байна.
- Эрдэнэ сум дахь МСҮТ-ийн 2020 оны 3 дугаар улирлын Хүнсний материалын зарцуулалтыг дотуур байрны хүүхдийн хоолны захиалгын хуудас, хоолны цэс, технологийн карттай түүвэрлэн тулгалт хийхэд 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй зарлагдсан, хүнсний материалын үлдэгдэлд тооллого хийхэд 33 нэр төрлийн материал дутуу, 5 нэр төрлийн материал илүү 4.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.
- Эрдэнэ сум дахь МСҮТ-ийн 2020 оны жилийн эцсийн эд хариуцагчийн картыг тулган тооллого хийхэд зарим нэр төрлийн хөрөнгийг бүртгээгүй зөрүүтэй байв.
- Төв аймаг дахь МСҮТ-ийн тооллого комиссын гишүүд НХМаягт БМ-8 хөтлөөгүй, 3,216.2 сая төгрөгийн хөрөнгийн тооцоо бодож тооллогын комиссын гишүүд баталгаажуулаагүй, няравууд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, нярав солигдоход тооллого хийж тооцоо боддоггүй байна.
- Төв аймаг дахь МСҮТ-ийн хүнсний материалын үлдэгдлийг 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр тулган баталгаажуулахад 0.4 сая төгрөгийн 4 нэр төрлийн материал дутагдаж, 0.3 сая төгрөгийн 9 нэр төрлийн материал илүүдсэн.
- Төв аймаг дахь МСҮТ-ийн хүнсний материалын тайланг анхан шатны баримт хуримтлуулах хүснэгтийн дүнтэй тулгахад дотуур байрны хүүхдийн хоолонд хэрэглэсэн хуримтлуулах хүснэгтэд заагдсан бараа материалын тоо хэмжээ, үнийн дүнг зөрүүтэй, нийт дүнг тааруулан тайлагнасан. 2019 онд хүнсний материалын зарлагын журналын дүн хуримтлуулах хүснэгтээс 2.5 сая төгрөгөөр илүү зарцуулсан, 2020 онд хүнсний материалын зарлагын журналаас 8 нэр төрлийг тулгахад 61.6 мянган төгрөгийн 1 нэр төрөл дутуу, 7 нэр төрлийн 1.0 сая төгрөгийг илүү зарцуулсан байна.
- Заамар сум дахь МСҮТ нь 2020 оны жилийн эцсийн тооллогоор бэлэн байсан хүнсний материалын үлдэгдлээс хугацаа дуусах, чанар байдал алдагдах 2.0 сая төгрөгийн материал, түлш шатах тослох материалын 1.3 сая төгрөгийн шатахууныг бэлтгэн нийлүүлэгчид буцаалт хийсэн байна
- Заамар сум дахь МСҮТ нь Жи-мобайл ХХК-с түрээсийн гэрээний дагуу сард бүр 0.1 сая төгрөгийн түрээсийн орлогын тооцоог тооцож аваагүй, авлага үүсгээгүй 0.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- Заамар сум дахь МСҮТ нь 2020 оны жилийн эцсийн тайлангаар 37.9 сая төгрөгийн 439 толгой малтай, энэ оны төлийг орлого авсан байдлаар 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр малын гэнэтийн тооллого хийж тулган баталгаажуулахад 45 толгой хонь дутуу байсан зөрчлийг илрүүлж, аудитын явцад малчинтай хийсэн гэрээний дагуу шийдвэрлэж малын тоо толгойг бүрэн болгож байгууллагын им тэмдгээр тэмдэглэж зөрчлийг арилгуулж, зургаар баримтжуулсан.
- Заамар сум дахь МСҮТ-ийн Үндсэн хөрөнгө нь байгууллагын онцлогт тохирсон лого, дахин давтагдахгүй код бүхий тусгай наалт, таних тэмдэг байхгүй байна
- Заамар сум дахь МСҮТ-ийн 2019, 2020 оны тооллогын комиссын бүрэлдэхүүнд байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нар орсон байгаа нь холбогдох хууль тогтоомжтой "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

- Баянчандмань суман дахь Политехник коллежийн тээврийн хэрэгслүүд тооллогоор дутагдсан зөрчил илэрлээ.

БҮЛЭГ В. Дотоод хяналт шалгалт үр нөлөөтэй хэрэгжиж чадахгүй байна.

3.1 Өдөр тутмын үйл ажиллагаанд тавьж байгаа дотоод хяналт сул байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолд аж ахуйн нэгж, албан байгууллагууд нь өөрийн байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг батлан мөрдөж ажиллахаар заасан байдаг. Аудитад хамрагдсан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн хувьд өөрийн байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг батлан мөрддөггүй, дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөгөө үндэслэл муутай баталдаг, дотоод хяналт шалгалт хийх тухай бүр удирдамж батлуулдаггүй, дотоод хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зөрчлийн арилгасан талаар хамт олны болон удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэггүй зэрэг нийтлэг зөрчлүүд байна.

Баянчандмань сумын ПК нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/185 тоот тушаал, Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Б/05 тоот тушаалыг тус тус үндэслэн Хяналт шинжилгээ мониторинг хариуцсан ахлах мэргэжилтний ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулан 2021 оны 01 дүгээр сарын 04 ний өдрөөс эхлэн Дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтнаар ажиллах болсон. Албан тушаалын нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан ХНХЯ-аас ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн явуулна гэсэн боловч ирээгүй байгаа учир ЗГ-ын 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтыг бүрэн гүйцэт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Заамар сум дахь МСҮТ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт шалгалтыг 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд анхан шатны баримтын бүрдүүлэлт, тооллого тооцооны талаар хяналт шалгалт хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал тавьж ажилласан байна.

Эрдэнэ сум дахь МСҮТ-ийн дотоод хяналт шалгалтыг 2019 онд сургуулийн захирлын тушаал, баримт бичгийн бүрдэлд баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулан хяналт шалгалт хийж, 2020 онд санхүүгийн үйл ажиллагаа, суралцагсдын баримт бичиг, ирцийн бүртгэл, шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж сургалтын албанд 1, нягтлан бодогчид 3 зөвлөмж өгч хэрэгжилтийг гаргуулан ажилласан байна. 2017-2022 оны хөгжлийн хөтөлбөрийн 4 зорилтын хүрээнд 104 ажлыг төлөвлөсний 2020 оны байдлаар хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг хийхэд 75 ажил бүрэн хийгдэж 84,3%-тай гарсан байна.

Төв аймаг дахь МСҮТ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж танилцуулсан байна.

3.2 Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс 5 жил тутамд магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийгдсэн байна.

Салбарын яамны дотоод хяналт шинжилгээний багаас хийгдсэн шалгалт байхгүй дотооддоо сургалтын албанаас МБСБ-ын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журмын дагуу сар бүр багш нарын танхимын бус багц цагийн хуудсанд хяналт хийж багш нар багц цаг тооцуулахдаа нотлох баримтаар баталгаажуулах талаар санхүүгийн албанд зөвлөмж хүргүүлсний үр дүнд багш бүр хийсэн ажлаа баримтжуулж ажилласан байна.

БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу Баянчандмань сумын Политехникийн коллеж 2019 онд, Төв аймаг дахь МСҮТ 2020 онд, Эрдэнэ сум дахь МСҮТ 2021 онд магадлан итгэмжлэгдсэн байна.

Заамар сум дахь МСҮТ стандарт үзүүлэлтүүдийн дагуу эрхэм зорилго, зорилт, санхүү эдийн засаг, барилга байгууламж, материаллаг нөхцөл, сургалтын агуулга, багш, суралцагч, номын сан, удирдлага зохион байгуулалт зэрэг чиглэлээр үйл ажиллагаандаа иж бүрэн үнэлэлт, дүгнэлт өгөх өөрийн үнэлгээний тайланг бэлтгэх үе шатны ажил хийгдэж байна.

Магадлан итгэмжлэлийг 1-д захиргаа удирдлага, 2-д сургах ба сурах үйл ажиллагаа, 3-д багш ажилтан, 4-д сургалтын үйл явцын судалгаа хөгжил, 5-д Сурагчдад чиглэсэн үйлчилгээ, 6-д нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа, 7-д нөөц, 8-д Үндэсний болон олон улсын хөдөлмөрийн зах зээлийн шаардлага сургалтын байгууллагын дүйцэл гэсэн үзүүлэлтүүдээр нөхцөл байдал, давуу тал, сул талыг тодорхойлон шинжээчийн нэгдсэн дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан байна.

3.3 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдад олгосон тэтгэлгийг Mergejil.mn сайтад байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Засгийн газрын 2020 оны 44 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын дагуу суралцагчид олгох тэтгэлгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож байна. ХНХЯ-ын Mergejil.mn сайтад сургуулийн суралцагчдын мэдээллийг оруулж сар бүрийн ирцийг шивэн тэтгэлэг олголтыг тогтмолжуулан ажиллаж байгаа бөгөөд 2019 онд 4520, 2020 онд 10298 суралцагч тэтгэлэгт хамрагдсан байна.



3.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн хугацаанд нь байршуулж мэдээлсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах нийтлэг зөрчил байна. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийг мэдээлэхдээ өмнөх сарын мэдээллийг өөрчлөөгүй, хэтрэлт хэмнэлт, түүний тайлбарыг мэдээлдэггүй, мэдээлсэн хэдий ч үнэн зөв тайлагнаагүй, шалтгаан тайлбарыг тодорхой бичдэггүй, хугацаа хоцроож байршуулсан.
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын дүнг зөрүүтэй мэдээлсэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж байршуулаагүй байна. Тухайлбал:

Заамар сум дахь МСҮТ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахдаа шилэн дансны цахим хуудаст захирлын нэр өөрчлөгдөөгүй, Төсвийн хэмнэлтийн тайлбар бичигдээгүй, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтад улсын төсвөөс авсан санхүүжилтийг мэдээлсэн ч худалдан авалтыг мэдээлэхдээ гэрээний үнийн дүнгээс хэтэрсэн санхүүжилт өгсөн мэт харагдаж байгаа нь мэдээллийг алдаатай оруулсан нь Төв аймаг дахь МСҮТ 2019 онд 81 мэдээллийг хугацаа хоцроож байршуулахдаа 6, 7 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг өмнөх сарын мэдээг өөрчлөөгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг 1, 6-р сард 48.1 сая төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж байршуулаагүй, Эрдэнэ сум дахь МСҮТ 2019, 2020 оны шилэн дансны мэдээллийг шалгахад 2019 онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 149 мэдээллээс огт байршуулаагүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон төлөвтэй 15 мэдээлэл, хугацаандаа 132 мэдээллийг байршуулсан байна. 5 сая төгрөгөөс дээш өссөн дүнгээр 49.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтыг 1, 7-р сард, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргаж байршуулаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хууль, эрх зүйн орчин бүрдэж орон нутагт үр дүнтэй хэрэгжиж 2017-2020 оны судалгаагаар нийт төгсөгчдийн 54,4 хувь нь ажлын байраар хангагдсан байна.
2. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжиж сургалтын материаллаг баазыг бүрдүүлсэн хэдий ч техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр харилцан адилгүй хангагдсан байна.
3. Салбарын яамны дотоод хяналт шинжилгээний багаас хийсэн хяналт шалгалтын тайлан байхгүй, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс 5 жил тутамд магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээний тайлан бичигдсэн байна.
4. Суралцагчдын тэтгэлэг олголтын явцад хяналт-шинжилгээ үнэлгээ тусгайлан хийгдээгүй ба Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдад олгох тэтгэлэгийг журмын дагуу олгож, олон нийтэд ил тод мэдээлсэн байна.
5. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төсвийн төсөлд өгсөн саналыг өөрчлөн баталж байгаа нь төсвийг зөрүүтэй төлөвлөх үндэслэл болж байна.
6. Батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, агуулахын эмх цэгц, хөрөнгийн тооллого, тооцоо бодолт хангалтгүй байна.
7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн МСҮТ-үүдийн захирал, нягтлан бодогч нарт зөвлөх нь:

1. Үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, багш нарын багц цагт олгож байгаа нэмэгдэл, тасаг нэгжийн нэмэгдлүүдийг дүгнэсэн шалгуур үзүүлэлтүүд, ажлын хэсгийн үнэлэлт, хийсэн ажлын үр дүнг үндэслэн холбогдох журам, тушаал шийдвэрийн дагуу тооцон олгох
2. МБЭСБ-ын багш ажиллагсдын цалинг Засгийн газрын 2019 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 276 дугаар тогтоолын дагуу албан тушаалын зэрэглэлийн жишгийг зөв мөрдөх
3. Байгууллагын эд хөрөнгийн тооллого тооцоо, бодолтыг хуулийн хугацаанд чанартай хийж, хөрөнгөнд байгууллагын онцлогт тохирсон лого, дахин давтагдахгүй код бүхий тусгай наалт, таних тэмдэгжүүлэх хөрөнгө солигдох эрсдэлээс хамгаалж, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллах ба тооллогын үр дүнг баталгаажуулж хэвших
4. Хөрөнгө, бараа материал дутагдуулсан, данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, бүртгэл тайланг зөрүүтэй тооцсон, тооллого тооцоог үнэн зөв хийгээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх
5. Төсвийн хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, хууль тогтоомжид нийцүүлэн захиран зарцуулж, төсвийн сахилга батыг чанд мөрдөх
6. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд нь иж бүрэн, үнэн зөвөөр байршуулж, мэдээлж байх

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

О.АМАРЖАРГАЛ

Т.МАЙЦЭЦЭГ

Ц.САРАНЧИМЭГ

Ж.БЯМБАЦОГТ

Д.БЯМБАСҮРЭН

Г.БАЯНЖАРГАЛ

Т.ХҮРЭЛБААТАР

